

## ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

### Тавигдах болзол, шаардлага:

- төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

### Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/.

### Материал хүлээн авах:

- Хугацаа: 2023 оны 05 сарын 30-ны өдрийн 15.00 цаг хүртэл
- Хүлээн авах хаяг: [ariunzul@mddc.gov.mn](mailto:ariunzul@mddc.gov.mn)
- Холбоо барих утас: 266210 (гар утаснаас залгах бол 51266210)

**Шилжүүлэх, сэлгэн авах ажлын байрны жагсаалт:**

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага			
					төрөл	ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
1	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	Бодлого, төлөвлөлтийн газар	Газрын дарга	1	Төрийн захиргааны удирдах	Эрхэлсэн түшмэл ТЗ-2	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;	<a href="https://mddc.gov.mn/wp-content/uploads/2023/05/71-1.БТГ-Газрын-дагра.pdf">https://mddc.gov.mn/wp-content/uploads/2023/05/71-1.БТГ-Газрын-дагра.pdf</a>	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх;	Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх;
2	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	Яамны болон салбарын агентлаг, харьяа байгууллага, төслийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх асуудал хариуцсан ахлах шинжээч, аудитор	1	Төрийн захиргааны гүйцэтгэх	Ахлах түшмэл ТЗ-4	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх	<a href="https://mddc.gov.mn/wp-content/uploads/2023/05/72-8.ХШУДАГ-Яамны-болон-салбарын-агентлаг-харьяа-байгууллагын-ахлах-шинжээч-аудитор.pdf">https://mddc.gov.mn/wp-content/uploads/2023/05/72-8.ХШУДАГ-Яамны-болон-салбарын-агентлаг-харьяа-байгууллагын-ахлах-шинжээч-аудитор.pdf</a>	-Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх; -Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний зөвшөөрлөөр албан ёсоор зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх;	-Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх;  -Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх;

3	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	Яамны ажиллагаа, харьяа байгууллагын төсөл хөтөлбөрийн ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн үйл	1	Төрийн захиргааны гүйцэтгэх	Дэс түшмэл ТЗ-7	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх	<a href="https://mddc.gov.mn/wp-content/uploads/2023/05/74-21.XШҮДАГ-Яамны-үйл-ажиллагаа-төсөл-хөтөлбөрийн-үйл-ажиллагаа-хариуцсан-мэргэжилтэн.pdf">https://mddc.gov.mn/wp-content/uploads/2023/05/74-21.XШҮДАГ-Яамны-үйл-ажиллагаа-төсөл-хөтөлбөрийн-үйл-ажиллагаа-хариуцсан-мэргэжилтэн.pdf</a>	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.
---	-------------------------------------	---	--	---	-----------------------------	-----------------	---	---	---

---oOo---